

Салхинцэцэг

Тодорхойлолт

Бага зэргийн халууралт ,арьсан дээрх
цэврүүт тууралтаар илэрдэг
цочмог халдварт өвчин юм.

Үүсгэгч: Хүний герпес вирусийн а дэд бүлэгт хамаарагдах ба 150-200 нм хэмжээтэй

Тархвар судлал:

Өвчний эх уурхай нь салхин цэцэг болон бүсэлхий яраар өвчилсөн хүмүүс

Халдвар дамжих зам нь

- Шууд хавьтлаар хүнээс хүнд
- Агаар дуслын замаар
- Халдвар авсан хүмүүсийн цэврүүг үрсэн эд зүйлээр шууд бус замаар халдварлана.

Нууц хугацаа 10-21 хоног буюу дунджаар 14-16 хоног байна.


Халдвартай байх үе нь тууралт гархаас 1-2 хоногийн өмнө , сүүлийн тууралт гарсанаас хойш 5 хоног үргэлжилнэ.



Эмгэг жам

0 – 3 хоног	<ul style="list-style-type: none">•Нүдний салст болон амьсгалын замаар халдвар нэвтэрч орно Захын тунгалгын булчирхайд репликаци болно
4 – 6 хоног	<ul style="list-style-type: none">•Анхдагч вирусемид•Элэг, дэлүү, бусад эрхтэнд вирусийн репликаци
10 – 12 хоног	<ul style="list-style-type: none">•Хоёрдогч вирусемид
14 хоног	<ul style="list-style-type: none">•Арьсны халдвар, цэврүүт тууралт

Салхин цэцэгийн үе шат



Тууралт

- Тууралт нь үе шаттай явагдана.
- Толбо, гүвдрүү, цэврүүтэй холимог тууралт гарна.
- 3-4 хоногт улайсан арьсан дээр тууралтын бүх элементүүд гардаг.



Тууралт нь дунджаар 250-500 ширхэг жижиг, шингэн агуулсан, улаан толбон тууралт арьсан дээр гардаг. Тууралт нь эхлээд нүүр, их биеээр гараад цааш бүх биеэр тархдаг. Цэврүү нь нэг хоёр өдрийн дараагаар булингартай болж хагарч тавшдаг. Цэврүүт тууралт нь дотроо тунгалаг шингэн агуулсан, эргэн тойрон улаан хүрээтэй, арьсанд нэвчдэс үүсгээгүй, гялтганасан өнгөтэй, голдоо хүйс маягийн хонхортой, тэмтрэхэд зөөлөн, янз бүрийн хэмжээтэй (1-2мм-ээс 5-6мм) бөгөөд хагалж үзэхэд цэврүү нь бүхэлдээ хагарч шалчийдаг учраас нэг хөндийтэй гэдэг.



Балархай хэлбэр: нь нууц хугацааны үед иммуноглобулин хийлгэсэн тохиолдолд үүснэ. Хөнгөн явцтай, биеийн халуун хэвийн, эсвэл бага зэрэг цөөн тооны толбон гүвдрүүт, ганц нэг цэврүүт жижиг тууралт гарна.

Тархмал хэлбэр: Нярайд эсвэл дархлал дарангуйлах эм удаан хугацаагаар хэрэглэсэн хүмүүст тохиолддог. Халууралт хордлогоос гадна дотор эрхтнүүд (элэг, уушиг, бөөр гэх мэт) гэмтдэг. Өвчин хүнд явцтай, нас баралтаар төгсөх нь элбэг.

Цусархаг хэлбэр: нь хүнд явцтай, ерөнхий хордлогын хам шинж хүчтэй илэрч, өндөр халуурах, цусархаг шингэн агуулсан цэврүүт тууралт гарахаас гадна цусархаг тууралт гарна. Мөн хамраас цус гоожих, гэдэснээс цус гарах, цустай ханиах зэрэг цусархагийн хам шинжүүд илэрдэг.

Том цэврүүт тууралтат хэлбэр: нь хүнд явцтай. Энэ үед 2-3 см-ийн хэмжээтэй том цэврүү гарч, тэр нь амархан хагарч арьсан дээр өнгөц шархлаа үүсгэснээс хоёрдогчоор нянгийн халдвараар хүндрэх нь элбэг



Хүндрэл

- Нянгын халдвар
- Энцефалит
- Хатгаа
- Нас баралт: 60,000 тохиолдолд 1



Төрөлхийн Varicella Syndrome

- Жирэмсний эхний 20 долоо хоног дотор
- <2%
- Жин бага төрөх, нүдний болон мэдрэлийн хүндрэл

Эмчилгээ

1. Үүсгэгчийн эсрэг: Ацикловир (зовиракс)-ыг 2-6 насны хүүхдэд хоногт биеийн жингийн кг тутамд 20 мг-аар тооцож 5 хоног хэрэглэнэ.

2. Шинж тэмдгийн

- Загатналт ихтэй үед харшлын эсрэг бэлдмэлүүд хлорфенамин, лоратадин, цетризин гм эмүүдийг тохирох тунгаар хэрэглэнэ.

- Шингэн алдалтаас сэргийлж амаар шингэн сайн уух. Уух шингэнд буцалсан ус, хорсол, шингэн баахуу, будааны шүүс зэрэг бага концентрацтай уусмалууд орно. Гэхдээ хүйтэн зүйл уухгүй

- Халууралттай халуун бууруулах парацетамол 10 мг/кг-р бодож уух эсвэл лаа хэлбэрээр ибупрофенийг хэрэглэнэ.
- Цэврүүт тууралтанд 1-2% -ийн бриллиантын ногоон болон метилийн хөх спиртэн уусмалыг түрхэнэ.
- Нүдэнд тууралт гарсан бол, 20%-ийн альбуцидын уусмалаас нүдэнд дусаана.
- Хэрэв бэлэг эрхтэн, амны хөндийн салст бүрхүүлд тууралттай байвал бэлэг эрхтнийг цэвэр усаар угааж тос түрхэх

Урьдчилан сэргийлэлт

- Өвчилсөн хүмүүсийг тусгаарлах
- Хэрэв та өвчилсөн хүнтэй цуг байсан урьд нь салхинцэцгээр өвчилөөгүй бол биеийн дархлаагаа дэмжих эм болон витамин эмчилгээг хийнэ